МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 27

"МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат хуульч Ж.Амарсанааг урьж "Монгол Улсын Үндсэн хууль, төрийн байгуулал" сэдвээр сургалт зохион байгууллаа.

Сургалтын явцад Үндсэн хуулийг дээдлэх ёс, үзэл баримтлал, хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, Монгол Улсын Үндсэн хуульд төрийн байгууллыг хэрхэн тодорхойлж тусгасан, түүний дотор шүүх эрх мэдлийн байгууллагын онцлог, Үндсэн хуулиар иргэдийн үндсэн эрхийг хэрхэн хангасан талаар сонирхолтой яриа өрнүүллээ.

Сургалтад Улс, Нийслэл, аймаг, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын 400 гаруй прокурор, ажилтан танхим болон цахим хэлбэрээр оролцсон байна.